ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэн-Уул сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/47/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай сум<br>2022 он | Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын<br>тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 99993365<br>Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Д.Пүүжмаа<br>Утас:99080797<br>Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ....................................................... **Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................................................... 4
3. Аудитын тайлан ....................................................... 14
 3.1 Ерөнхий зүйл ....................................................... 14
 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....................................................... 15
 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....................................................... 15
 3.4 Материаллаг байдал ....................................................... 15
 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....................................................... 16
 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....................................................... 16
 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....................................................... 17
 3.8 Аудитын гол асуудал ....................................................... 17
 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................................................... 17
 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................................................... 17
 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....................................................... 17
4. Аудитын илрүүлэлт ....................................................... 18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....................................................... 20

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.24. № 1302/406.
танай_________________-ны №__________________-т

ЦЭЦЭН-УУЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.РЭНЧИНСАМБУУ-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ажилтанд 0.7 сая төгрөгийн цалин, амралтын мөнгө давхардуулан олгосон, улс төрийн албан хаагчид тушаал шийдвэргүйгээр 2.0 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, инженер геологийн дүгнэлтийн 2.5 сая төгрөгийг зардлыг давхардуулан шилжүүлсэн, 6.0 сая төгрөгийн шийдвэргүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн, 6.3 сая төгрөгийн шатахууныг зарцуулахдаа шатахуун зарцуулалтын нормыг мөрдөж ажиллаагүй, 6.2 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй, ЗДТГ-ын дарга нь хувийн дансандаа 14.5 сая төгрөгийг төвлөрүүлэн бараа материал бэлтгэсэн, 3 галчийн 4.5 сая төгрөгийн цалинг халаалтын зардалд давхардуулан шилжүүлсэн, халаалтын зардлыг гэрээний дүнгээс 0.7 сая төгрөгийг илүү шилжүүлсэн зэрэг зөрчлүүд нь *Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16.5.5, 41.2.3; Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Татварын ерөнхий хуулийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3, 1.5 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй* байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

01302545 1

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2021 оны 12 -р сарын 31 өдөр *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)** | **12,985,605.62** | **32,016,347.32** |
| **33** | **АВЛАГА** | **121,179.42** | **1,468,656.12** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 121,179.42 | 160,481.12 |
| 33102 | НДШ-ийн авлага | 4,062.26 | 43,363.96 |
| 33103 | ХАОАТ-ын авлага | 117,117.16 | 117,117.16 |
| 33500 | Бусад авлага | 0.00 | 1,308,175.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 0.00 | 1,308,175.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **12,864,426.20** | **30,547,691.20** |
| 35400 | Хангамжийн материал | 12,864,426.20 | 30,547,691.20 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,808,575.00 | 2,244,475.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,472,091.20 | 22,431,091.20 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 470,000.00 | 3,399,950.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,780,760.00 | 1,308,175.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 767,000.00 | 598,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 566,000.00 | 566,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)** | **681,549,406.51** | **629,782,347.86** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **681,549,406.51** | **629,782,347.86** |
| 39200 | Биет хөрөнгө | 678,846,031.51 | 627,491,472.86 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 618,123,681.00 | 618,123,681.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | (93,551,614.52) | (118,787,388.68) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 129,384,800.00 | 129,384,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл | (83,882,400.20) | (102,810,533.56) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 65,997,519.40 | 72,585,519.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | (31,098,203.74) | (41,086,927.82) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 28,939,797.77 | 28,939,797.77 |

| | | | |
|---|---|---|---|
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | (19,337,706.68) | (21,630,016.64) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 115,108,490.00 | 122,608,490.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө | (52,928,281.52) | (61,925,898.61) |
| 39217 | Номын фонд | 2,089,950.00 | 2,089,950.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 2,703,375.00 | 2,290,875.00 |
| 39301 | Програм хангамж | 2,802,000.00 | 2,802,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж | (1,392,625.00) | (1,805,125.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,294,000.00 | 1,294,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)** | **694,535,012.13** | **661,798,695.18** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)** | **317,600.00** | 0.00 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **317,600.00** | 0.00 |
| 41300 | Өглөг | 317,600.00 | 0.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 317,600.00 | 0.00 |
| 413201 | Бичиг хэргийн өглөг | 317,600.00 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)** | **694,217,412.13** | **661,798,695.18** |

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **694,217,412.13** | **661,798,695.18** |
| 51101 | -Төрийн | 331,501,291.24 | 331,501,291.24 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 143,184,549.74 | 110,765,832.79 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 274,097,597.71 | 143,184,549.74 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (130,913,047.97) | (32,418,716.95) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 219,531,571.15 | 219,531,571.15 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)** | **694,535,012.13** | **661,798,695.18** |

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **353,205,389.00** | **434,794,818.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,447,520.00** | **8,150,000.00** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 8,447,520.00 | 8,150,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 8,092,520.00 | 8,050,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал | 355,000.00 | 100,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **344,757,869.00** | **426,644,818.00** |
| 1310 | Улсын төсвөөс | 339,969,800.00 | 358,585,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 332,969,800.00 | 358,585,500.00 |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | 7,000,000.00 | 0.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,788,069.00 | 68,059,318.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,788,069.00 | 68,059,318.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **413,402,349.84** | **467,213,534.95** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **413,402,349.84** | **467,213,534.95** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 370,850,512.95 | 449,704,690.09 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 229,722,487.84 | 225,448,753.00 |
| 210101 | Үндсэн цалин | 205,812,009.84 | 225,448,753.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,022,420.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 7,188,704.00 | 0.00 |
| 210105 | Гэрээт ажлын цалин | 14,699,354.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 26,379,621.73 | 29,164,485.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,665,666.33 | 20,785,482.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,947,954.65 | 2,209,717.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,558,041.42 | 1,767,773.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 382,970.36 | 400,139.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,824,988.97 | 4,001,374.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,170,526.13 | 13,337,263.14 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,864,631.13 | 2,672,663.14 |
| 210302 | Түлш, халаалт | 9,305,895.00 | 10,664,600.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,001,365.00 | 18,440,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,300,900.00 | 2,149,620.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,995,565.00 | 13,917,280.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,699,900.00 | 2,373,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,000.00 | 0.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 616,900.00 | 1,971,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 616,900.00 | 1,971,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,001,000.00 | 1,250,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,001,000.00 | 1,250,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,550,365.00 | 13,774,685.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,652,654.00 | 13,301,861.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 232,100.00 | 232,100.00 |

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 158,010.00 | 54,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 79,274.00 | 86,274.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн | 22,000.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | оношилгоо | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 300,000.00 | 100,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 106,327.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 76,408,247.25 | 146,317,403.65 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,400,000.00 | 80,462,345.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 249,280.00 | 0.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 72,758,967.25 | 65,855,058.65 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 42,551,836.89 | 17,508,844.86 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0.00 | 17,508,844.86 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0.00 | 17,508,844.86 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 26,384,400.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжп | 26,384,400.00 | 0.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 16,167,436.89 | 0.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,167,436.89 | 0.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **(60,196,960.84)** | **(32,418,716.95)** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **70,716,087.13** | 0.00 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 70,716,087.13 | 0.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 70,716,087.13 | 0.00 |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | **(130,913,047.97)** | **(32,418,716.95)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

# ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-** | **331,501,291.24** | **219,531,571.15** | **274,097,597.71** | | **825,130,460.10** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **нээрх үлдэгдэл** | | | | | |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 331,501,291.24 | 219,531,571.15 | 274,097,597.71 | | 825,130,460.10 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | | | | |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | | | | |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | | | (130,913,047.97) | | (130,913,047.97) |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | 331,501,291.24 | 219,531,571.15 | 143,184,549.74 | | 694,217,412.13 |
| 8 | Зарласан ноогдол ашиг | | | | | |
| 9 | Тайлант үеийн үр дүн | | | | | |
| 10 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | | | |
| **11** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **331,501,291.24** | **219,531,571.15** | **143,184,549.74** | | **694,217,412.13** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 331,501,291.24 | 219,531,571.15 | 143,184,549.74 | | 694,217,412.13 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | | | | |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | | | | |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | | | | | |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | |
| 18 | Зарласан ноогдол ашиг | | | | | |
| **19** | **Тайлант үеийн үр дүн** | | | **(32,418,716.95)** | | **(32,418,716.95)** |
| **20** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **331,501,291.24** | **219,531,571.15** | **110,765,832.79** | | **661,798,695.18** |

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **344,757,869.00** | **426,644,818.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **344,757,869.00** | **426,644,818.00** |
| 1310 | Улсын төсвөөс | 339,969,800.00 | 358,585,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 332,969,800.00 | 358,585,500.00 |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | 7,000,000.00 | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,788,069.00 | 68,059,318.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,788,069.00 | 68,059,318.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **339,807,869.00** | **420,606,818.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **339,807,869.00** | **420,606,818.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 297,256,032.11 | 403,097,973.14 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 229,839,605.00 | 224,279,805.86 |
| 210101 | Үндсэн цалин | 205,929,127.00 | 207,466,431.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,022,420.00 | |
| 210104 | Урамшуулал | 7,188,704.00 | |
| 210105 | Гэрээт ажлын цалин | 14,699,354.00 | 16,813,374.86 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 25,788,125.98 | 30,369,777.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,074,170.58 | 20,359,352.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,947,954.65 | 1,972,430.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,558,041.42 | 1,577,744.56 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 382,970.36 | 380,116.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,824,988.97 | 6,080,132.10 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 10,599,231.13 | 17,307,263.14 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,864,631.13 | 3,572,663.14 |
| 210302 | Түлш, халаалт | 8,734,600.00 | 13,734,600.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 17,484,525.00 | 16,656,190.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,444,200.00 | 2,599,720.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,340,425.00 | 11,682,870.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,699,900.00 | 2,373,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,343,900.00 | 3,684,050.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,343,900.00 | 3,684,050.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,001,000.00 | 1,250,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,001,000.00 | 1,250,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,550,365.00 | 13,777,642.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,652,654.00 | 13,304,818.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 232,100.00 | 232,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 158,010.00 | 54,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 79,274.00 | 86,274.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 300,000.00 | 100,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 106,327.00 | |

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,649,280.00 | 95,773,245.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,400,000.00 | 95,469,845.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 249,280.00 | 303,400.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 42,551,836.89 | 17,508,844.86 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | | 17,508,844.86 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | 17,508,844.86 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 26,384,400.00 | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжп | 26,384,400.00 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 16,167,436.89 | |

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,167,436.89 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)** | **4,950,000.00** | **6,038,000.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **4,950,000.00** | **6,038,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,950,000.00** | **6,038,000.00** |
| 223 | БУСАД ХӨРӨНГӨ | 4,950,000.00 | 6,038,000.00 |
| 223004 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4,950,000.00 | 6,038,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)** | **(4,950,000.00)** | **(6,038,000.00)** |
| **9** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | | |
| **10** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)** | | |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)** | | |
| **14** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **15** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

# ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2021 оны 12 -р сарын 31 өдөр *|төгрөгөөр/(УТ)*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүнгээр | % |
| **11000** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | | | | |
| **11100** | **Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | | | | |
| **11200** | **Кассын оны эхний үлдэгдэл** | | | | |
| **12** | **Татварын бус орлого** | **347,290,800.00** | **358,585,500.00** | **(11,294,700.00)** | **10.45** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 347,290,800.00 | 358,585,500.00 | (11,294,700.00) | 10.45 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | |
| 132004 | Оны эхний үлдэгдэлээс санхүүжих /орон нутаг/ | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **375,253,000.00** | **348,023,310.14** | **27,229,689.86** | **10.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **375,253,000.00** | **342,145,310.14** | **33,107,689.86** | **10.65** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **375,253,000.00** | **342,145,310.14** | **33,107,689.86** | **12.78** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **237,273,100.00** | **224,279,805.86** | **12,993,294.14** | **24.94** |
| 210101 | Үндсэн цалин | 211,757,100.00 | 207,466,431.00 | 4,290,669.00 | 27.94 |
| 210102 | Нэмэгдэл | | | | |
| 210104 | Урамшуулал | | | | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 25,516,000.00 | 16,813,374.86 | 8,702,625.14 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **32,031,800.00** | **30,369,777.14** | **1,662,022.86** | **25.14** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,540,900.00 | 20,359,352.86 | 2,181,547.14 | 23.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,372,800.00 | 1,972,430.65 | 400,369.35 | 19.68 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,898,200.00 | 1,577,744.56 | 320,455.44 | 19.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 474,500.00 | 380,116.97 | 94,383.03 | 18.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,745,400.00 | 6,080,132.10 | (1,334,732.10) | 36.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **17,605,800.00** | **17,307,263.14** | **298,536.86** | **48.58** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,071,200.00 | 3,572,663.14 | 498,536.86 | 87.76 |
| 210302 | Түлш, халаалт | 13,534,600.00 | 13,734,600.00 | (200,000.00) | 50.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **18,506,100.00** | **16,656,190.00** | **1,849,910.00** | **40.99** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,636,500.00 | 2,599,720.00 | 36,780.00 | 43.26 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,749,400.00 | 11,682,870.00 | 1,066,530.00 | 41.54 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,120,200.00 | 2,373,600.00 | 746,600.00 | 36.83 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,995,400.00** | **3,684,050.00** | **311,350.00** | **46.10** |
| 210604 | Урсгал засвар | 3,995,400.00 | 3,684,050.00 | 311,350.00 | 46.10 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,365,600.00** | **1,250,000.00** | **2,115,600.00** | **18.57** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,365,600.00 | 1,250,000.00 | 2,115,600.00 | 18.57 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж** | **2,561,800.00** | **1,672,824.00** | **888,976.00** | **9.23** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,273,800.00 | 1,200,000.00 | 73,800.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 232,100.00 | 232,100.00 | | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 54,450.00 | 414,650.00 | 11.61 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,700.00 | 86,274.00 | 141,426.00 | 37.89 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

## НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

*/төгрөгөөр/(НС)*

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)** | **61,112,663.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **60,952,663.00** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **60,952,663.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **12,104,818.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,104,818.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **48,847,845.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,847,845.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **160,000.00** |
| **223** | **БУСАД ХӨРӨНГӨ** | **160,000.00** |
| 223004 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 160,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)** | **68,059,318.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **68,059,318.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **68,059,318.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 68,059,318.00 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **6,946,655.00** |
| **11000** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **12000** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **6,946,655.00** |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэцэн-Уул сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл,тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Д.Пүүжмаа, ахлах аудитор Б.Дагвасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хэрэгжүүлсэн.

Цэцэн-Уул сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 3/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цэцэн-Уул сумын ЗДТГ нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэх зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэн-Уул сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын батлагдсан төсвийн 426.644,8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 6.399,6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын (60-80 хувиар) буюу 4.799,7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 121,2 | 1.468,6 | 1347.4 |
| Бараа материал | 12.864,4 | 30.547,7 | 17.683,3 |
| Үндсэн хөрөнгө | 681.549,4 | 629.782,3 | -51.767,1 |
| **Нийт хөрөнгө** | 694.535,0 | 661.798,7 | -32,736,3 |
| Өр төлбөр | 317,6 | 0,0 | 317,0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 694.535,0 | 661.798,7 | -32,736,3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 694.535,0 | 661.798,7 | -32,736,3 |

Авлага дансны үлдэгдэл 1347.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ХХОАТ, НДШ, аж ахуйн нэгж рүү илүү шилжүүлсэн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 17.683,3 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээж авсан бараа материал болон худалдан бэлтгэсэн бараа материалтай холбоотой байна .

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 51.767,1 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл мянган төгрөгөөр буурсан нь өр төлбөрийг барагдуулсантай байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 32,736,3 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 347.290,8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 347.290,8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 358.585,5 мянган төгрөгийн, санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 348.023,3 мянган төгрөгийг зарцуулж, 10.562,2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны байгууллагаас 54.859,3 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлсэн байна

Нэмэлт орлогын 47,912,7 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 6.946,6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Тээвэр шатахууны зарцуулалтын баримтууд дутуу, жолоочийн замын тооцооны хуудас нь зарцуулсан шатахуунтай зөрүүтэй, автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг мөрдөж ажиллаагүй, худалдан авалт хийхдээ и баримтыг бүрэн бүрдүүлээгүй, шийдвэргүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн, сумын тамгын газрын дарга нь өөрийн хувийн дансандаа мөнгө авч үндсэн хөрөнгө болон бараа материал бэлтгэсэн, халаалтын хөлс гэрээний дүнгээс илүү шилжүүлсэн, цалин хөлсний тооцоолол буруу хийсэн зэрэг зөрчлүүд байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроосон 7 мэдээлэл байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шатахууны зарцуулалт, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлд анхаарах шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 67.750,1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 17.508,8 мянган төгрөгийн алдааг залруулж, 7.892,6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч, 26.932,0, мянган төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж, 10.416,7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

### 4.1 Залруулсан алдаа

Төвлөрүүлэх шилжүүлгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 17.508,8 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Засаг даргад 746,1 мянган төгрөгийн цалин амралтын мөнгийг давхар бодож олгосон, халаалтын зардалд гэрээний үнийн дүнгээс 696,9 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн,Улс төрийн албан хаагчид тушаал шийдвэргүй 1,996,9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, сургуулийн 100 хүүхдийн дотуур байрны инженер геодезийн зураг төсвийн үнэ 2,500,0 мянган төгрөгийг аж ахуйн нэгж рүү шилжүүлсэн, сургууль нь тухайн зураг төсвийн үнийг бүрэн шилжүүлсэн ч, Засаг даргын тамгын газар нь уг мөнгийг авлага үүсгэн тайлагнаагүй, давхардуулан олгосон, төвлөрсөн халаалтад шилжиж галч нарыг халаалт ханган нийлүүлэгч Ти Жи Өү Жи компани нь ажилтнаар авч ажиллуулсан байна.Харин тухайн галч нарын цалинг Засаг даргын тамгын газрын цалингийн сангаас дээрх компани руу 4,476,81 мянган төгрөгийг шилжүүлсэн нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3 “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон нь”,4.2.3.5 бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн нийт 10.416,7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

### 4.3 Албан шаардлага

Тээвэр шатахууны зарцуулалтын баримтууд дутуу, жолоочийн замын тооцооны хуудас нь зарцуулсан шатахуунтай зөрүүтэй, автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг мөрдөж ажиллаагүй 6,242,6 мянган төгрөгийн зөрчил, ИТХ-ын шийдвэргүйгээр 6,038,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, сумын тамгын газрын дарга нь 14,530,0 мянган төгрөгийг өөрийн хувийн дансандаа авч үндсэн хөрөнгө болон бараа материал бэлтгэсэн зөрчлүүдийг Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.2.1.-д “...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө”, 4.2.1.6- “төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.11” хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн нийт 26.932,0 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүллээ

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *6242.6 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримт /и-баримт/-ыг бүрэн бүрдүүлээгүй;*
- ✓ *1650,0 мянган төгрөгийн үнэтэй 2020 онд худалдан авсан Си-Ти-Эс ХХК-ний нягтлан бодох бүртгэлийн болон няравын программыг 2021 онд ашиглаагүй.*

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

- ✓ *Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах;*

- ✓ *Си-Ти-Эс ХХК-ний нягтлан бодох бүртгэлийн болон няравын программыг бүрэн ашиглаж хагас жилийн санхүүгийн тайланг гаргах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06  дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1. | Цэцэн-Уул сумын ЗДТГ | 5 | 62,7 | 1 | 17,5 | 1 | 10,4 | 1 | 26,9 | 2 | 7,9 |